

ГУРВАН УЛСЫН УЛСЫН ХИЛИЙН УУЛЗВАРУДЫН  
ЦЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭР

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятаад Ард Улсын Засгийн газар /цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэж нэрлэх/,

гурван улсын хоорондын сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор,

бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх, энх тайвинаар зэрэгцэн орших зарчмыг удирдлага болгож,

гурван улсын хил орчмын газар нутгийг бат бэх энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны бус болгохыг эрмэлзэж,

гурван улсын хиллийн уулзваруудын хоёр цэгийг гэрээ хэлэлцээрээр тодорхойлох шаардлагыг иш үндэс болгон,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондох Таван Богд /Таван-Богдо-Ула/ уулын 4104,0 тоот өндөрлөгөөс Асгатын Давааны Хярын /Асхатин-Дабани-Хяр/ орой хүртлийн баруун хэсэг, Их Саяаны нурууны /Большой Саян/ 2855,8 тоот өндөрлөгөөс Тарваган Дахын /Тарбаган-Дах/ овоо хүртлийн зүүн хэсгийн тухай 1976 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн монгол-зөвлөлтийн хилийн Гэрээ,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятаад Ард Улсын 1962 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн улсын хилийн тухай Гэрээ,

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Бүгд Найрамдах Хятаад Ард Улсын хоорондын зөвлөлт-хятаадын улсын хилийн зүүн хэсгийн тухай 1991 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Хэлэлцээрийн болон хилийн тухай орос-хятаадын холбогдох гэрээнүүдийн дагуу,

дор дурдсан зүйлүүдийг тохиролцов.

#### Нэгдүгээр зүйл

Монгол, Орос, Хятад улсын улсын хилийн Зүүн уулзварын цэг нь 645,0 тоот бүхий өндөрлөг дээрх Тарваган Дахын овооны төвд оршино.

Уг цэг нь Монгол Улсын нутагт орших 692,4 тоот бүхий өндөрлөгөөс зүүн хойдны зүүн зүгт ойролцоогоор 6,1 километрт, Оросын Холбооны Улсын нутагт орших 741,4 тоот бүхий өндөрлөгөөс эмнэ зүгт ойролцоогоор 5,0 километрт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутагт орших 709,0 тоот бүхий Шилийн Хэлэлтийн уулаас хойд зүгт ойролцоогоор 14,8 километрт байна.

Турван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгт хилийн тэмдэг /"Тарваган дах" нэртэй, "0" дугаартай хилийн дан багана/ босгоно.

Турван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн тэгш өндөгт солбицлыг багажаар тодорхойлно.

#### Хоёрдугаар зүйл

Монгол, Орос, Хятад улсын улсын хилийн Баруун уулзварын цэг нь Таван Богд /Хүйтэншань, Таван-Богдо-Ула/ уулын 4082,0 /4104,0/ тоот бүхий орой дээр оршино. Уг цэг нь Монгол Улсын нутагт орших 3884,0 тоот бүхий өндөрлөгөөс баруун хойдны баруун зүгт ойролцоогоор 6,1 километрт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутагт орших 3608,0 тоот бүхий өндөрлөгөөс зүүн хойдны хойд зүгт ойролцоогоор 4,8 километрт, Оросын Холбооны Улсын нутагт орших 3511,5 тоот бүхий өндөрлөгөөс баруун эмнийн баруун зүгт ойролцоогоор 9,4 километрт байна.

Хэлэлцэн тохирогч Талууд турван улсын улсын хилийн Баруун уулзварын цэгийг газар дээр нь тэмдэглэхгүйгээр тохиролцов.

Гурван улсын улсын хилийн Баруун уулзварын цэгийн төгш өндөгт солбицлыг багажаар тодорхойлно.

#### Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан гурван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийг Оросын Талын 1981 онд хэвлэсэн I:100 000-ны масштабтай газрын зурагт харуулав /Хавсралт I/.

Энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд дурдсан гурван улсын улсын хилийн Баруун уулзварын цэгийг Оросын Талын 1982 онд хэвлэсэн I:100 000-ны масштабтай газрын зурагт харуулав /Хавсралт 2/.

Эдгээр газрын зургууд нь энэхүү Хэлэлцээрийн хавсралт болно.

Дээр дурдсан зай, өндрийн тоотуудыг эдгээр газрын зургаас авсан болно.

Холбоосуудын газарзүйн нэрийг монгол, орос, хятад хэлээр тэмдэглэв.

#### Дөрөвдүгээр зүйл

Монгол, Орос, Хятад улсын улсын хилийн уулзваруудын хоёр цэгийн бодит байршилыг тодорхойлохын тулд Хэлэлцэн тохиrogч Талууд Хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэж, гурван улсын улсын хилийн хоёр уулзварын Тодорхойлолт-протокол, хилийн Зүүн уулзварын Тодорхойлолт-протоколд хавсаргах I:10 000-ны масштабтай газрын зураг, хилийн Баруун уулзварын Тодорхойлолт-протоколд хавсаргах I:25 000-ны масштабтай газрын зураг үйлцэн, Зүүн уулзварын цэгт хилийн "Тарваган дах" тэмдэг босгож, уг хилийн тэмдгийн Протокол үйлдэхийг тус тус хариуцуулахаар тогтов.

Дээр дурдсан Тодорхойлолт-протоколууд, тэдгээрт хавсаргах газрын зургууд болон хилийн тэмшгийн Протоколд Хэлэлцэн тохиrogч Талуудын төлөөлөгчид гарын үсэг зурна.

Эдгээр бичиг баримтууд хүчин төгөлдөр болсноор хамтарсан ажлын хэсгийн ажил дуусгавар болно.

Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрт 1994 оны 1 дүгээр сарын 27-нийөдөр Чингисханы монголын эмнэлэгийн хотноо гарын үсэг зурж монгол, орос, хятад хэлээр тус бүр гурван хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь ашил хүчинтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ӨМНӨӨС

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМДАХ  
ХИТАЛ АРД УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН  
ӨМНӨӨС



裴家义